



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 8/144

Номгон

Мод тарих ажлын санхүүжилтийг
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 31 дүгээр зүйлийн 31.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2024 оны 04/27 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 80 дахь хэсэг, “Мод тарих чиглэлээр хамтран ажиллах” 2022/62 дугаар гэрээний 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2024 оны А/480 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу “Шинэ баян сайр” ХХК-ний Шинэ суурьшлын бүсийн хамгаалалтын ойн зурваст тарьж 20 см-ээс дээш ургуулсан 25106 ширхэг модны төлбөрт 171,060,000 (Нэг зуун далан нэгэн сая жаран мянга) төгрөгийн санхүүжилтийг олгосугай.

2.Дээрх санхүүжилтийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Тарьсан моднуудын арчлалт, хамгаалалтыг гэрээний 3.2 дахь заалтын дагуу хариуцан ажиллахыг “Шинэ баян сайр” ХХК (Х.Баянмөнх)-д, модыг орон нутгийн өмчид бүртгүүлж, ургалтад хяналт тавьж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга (М.Насанбат)-д тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

625010415

W:\2025 ONZAKHIRAMJ\ЗАХИРАМЖ+++.DOCX1

